



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/136

Харлэн сум

Ой, хээрийн гал түймрээс урьдчилан
сэргийлэх ажлыг эрчимжүүлэхэд хөрөнгө
зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.13, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.10, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалт, Улсын Онцгой комиссын 2022 оны "Ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай" 01 дүгээр албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хаврын хуурайшилтын улирал эхэлж ой, хээрийн түймрийн эрсдэл нэмэгдэж байгаатай холбогдуулан урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулсугай.

2.Урьдчилан сэргийлэх чиглэлээр орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон олон нийтэд хүртээмжтэй бүхий л төрлийн арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Онцгой байдлын газрын дарга (хурандаа Ж.Эрдэнэбат), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж ажиллахад шаардагдах алба хаагчдын хоол, тараах материал, тээврийн хэрэгслийн шатахууны зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

4.Хөрөнгө зарцуулалтад шаардагдах 25.001.000 (хорин таван сая нэг мянган) төгрөгийг Засаг даргын нөөц сангийн гамшгийн эрсдэлийг бууруулах зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

5.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010374

СУМДАД АЖИЛЛАХ ШУУР КАЙ БҮЛГИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

ХҮНСНИЙ ТООЦОО									
Д/Д	хүнс бүтээгдэхүүний нэр төрөл	1 хүний хоногийн хэмжээ /гр/	ажиллах хүний тоо	нэг өдөрт /кг/	өдөрт 2 хоол	ажиллах хоног / 30 /	нийт /кг/	Нэг бүрийн үнэ	бүгд үнэ
1	мах	0.21	12	2.52	5.04	30	151	14000	2116800
2	гурил	0.12	12	1.44	2.88	30	86	3350	289440
3	цагаан будаа	0.04	12	0.48	0.96	30	29	2800	80640
4	ургамлын тос	0.025	12	0.3	0.6	30	18	7000	126000
5	элсэн чихэр	0.02	12	0.24	0.48	30	14	3000	43200
6	гоймон	0.02	12	0.24	0.48	30	14	10000	144000
7	төмс	0.10	12	1.2	2.4	30	72	1500	108000
8	сонгино	0.02	12	0.24	0.48	30	14	4200	60480
9	Манжин	0.02	12	0.24	0.48	30	14	4500	64800
10	Лууван	0.02	12	0.24	0.48	30	14	2900	41760
11	байцаа	0.04	12	0.48	0.96	30	29	4500	129600
12	талх	0.03	12	0.36	0.72	30	22	3500	75600
13	хоол амтлагч /Цай, давс, вигор, сүү /								50000
Нэг бүлэгт ноогдох хоолны дүн									3330320
5 бүлэгт нийт									16651800
ШАТАХ ТОСЛОХ МАТЕРИАЛЫН ТООЦОО									
1	Хойд сумдад А-80 бензин	Явах маршрут	явах зай /км/	шатахуун /л/	нэгж үнэ	нийт үнэ			
		Бор-Өндөр-Галшар	120	21.6	2420	52272			
		Галшар сумын 5 багийн айл өрх	258	46.4	2420	112288			
		Чингис хот-Өнмөдэлгэр	120	21.6	2420	52272			
		Өнмөдэлгэр сумын 4 багийн айл өрх	600	135	2420	210600			
		Өнмөдэлгэр-Батширээт сум	100	18	2420	35100			
		Батширээт-4 багийн айл өрх	450	81	2420	157950			
		Батширээт-Биндэр сум	70	12.6	2420	136500			
		Биндэр сумын 5 багийн айл өрх	500	90	2420	217800			

		Биндэр - Баян- Адарга сум	100	18	2420	35100
		Бэрх тосгоноос Дадал сум	200	36	2420	87120
		Дадал сумын 3 багийн айл өрх	105	18.9	2420	45738
		Баян- Адарга сумын 5 багийн айл өрх	400	90	2420	140400
		Дадал сумаас Бэрх тосгон	170	30.6	2420	59670
		Дүн	3193	619.7	2420	1342810
		масло тос				
2	нэг бүлэгт		0	2	12500	25000
		5 бүлэгт нийт				
		125000				
		СЭРЭМЖЛҮҮЛЭГ МАТЕРИАЛЫН ТООЦОО				
		Санамж материалын нэр	тоо ширхэг		нэгж үнэ	нийт үнэ
1	Иргэдэд тараах материал	ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх шторк	2 төрлийн		441000	882000
		Ой хээрийн түймэр	4000		1500	6000000
		Нийт дүн				
		25,001,000				